



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 127

Чойбалсан

Г Коронавируст халдвар /КОВИД-19/-ын гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний багцыг батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, 34.2.6, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3, 12.2.8, 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/456 дугаар тушаалын 6 дугаар хавсралт, А/549 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны А/337/99 дүгээр тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 116 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 84 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын хөнгөн хэлбэрийг гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний жишиг багцыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Ч.Оюунтунгалаг, Нийгмийн эрүүл мэндийн төв /Б.Сарнай/ нарт даалгасугай.

3.Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Өрх, сумын эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн Б.Гантуяад даалгасугай.

ДАРГА



Ч.ОЮУНАА

Эрүүл мэндийн газрын даргын оны
09 дугаар сарын 22 ны/ний өдрийн
..... дугаар/дүгээр тушаалын
хавсралт



ГЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИШИГ БАГЦ

№	Зардлын нэр		Үнэ /төгрөг/
1	Эмийн зардал	Вирусын эсрэг эм	76000
		Дархлаа дэмжих бүлгийн эм	
		Халуун бууруулах буюу зовиур багасгах, өвдөлт намдаах бүлгийн эм	
		Халдвар харшлын гаралтай эм	
		Уламжлалт эм	
2	Оношилгоо	Түргэвчилсэн оношлуур	15000
3	Хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, бусад хэрэгсэл		22000
4	Цалин, урамшуулал		32000
5	Үзлэгийн хөлс		10000
6	Бусад /шатахуун, хоол, холбоо/		5000
Нийт			160 000

ooOoo